

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, СУМДЫН
2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.08.01

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Хуралдаан 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хуралдан 6 асуудал хэлэлцэж, тус хуралдаанаас 4 тогтоол гарган баталлаа. Эдгээр тогтоолуудын товч утга нь:

1.Гол мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалгүй 47 байршлын 633,64 га талбайн газрыг бичил уурхайн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар аймгийн тусгай хэрэгцээнд авлаа.

2. Аймгийн ИТХ-ын шийдвэрээр аймгийн тусгай хэрэгцээнд авсан Ерөө сумын Өлөнт, Цамхаг, Могойн гол нэртэй газрын хил заагийн солбицлыг өөрчлөн тогтоов.

3.Аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн орлогын гүйцэтгэлийг 77044709,8 мянган төгрөгөөр, төсвийн зарлагын гүйцэтгэлийг 76839407,9 мянган төгрөгөөр тус тус баталлаа.

4. Аймгийн 2018 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг шинэчлэн баталлаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2018оны 07 дугаар сарын 06–ны өдрийн 92 дугаар зарлигаар Сэлэнгэ аймгийн харъяат зарим иргэдийг Монгол Улсын одон, медалиар шагнасан бөгөөд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 7 иргэн, Алтангадас одонгоор 56 иргэн, Хөдөлмөрийн хүндэт медалиар 43 иргэн, Цэргийн гавьяаны одонгоор 3 иргэн, Цэргийн хүндэт медалиар 5 иргэнийг тус тус шагнасныг 07 дугаар сарын 10-ны өдөр гардуулан өгсөн.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар.

АймгийнЗасагдаргаШ.Оргил “СэлэнгэСэтгэл” төрийнбусбайгууллагынтөлөөлөгчдийгхүлээнавчуулзанхамтранажиллахсанамжбичигтгарынүсэгзурлаа.Санамжбичгийнүндсэнзорилгонь Сэлэнгэаймгийнхэмжээндсоёл, урлаг, спорт, байгальорчин, нийгмийнсалбарттөсөл, хөтөлбөрхэрэгжүүлэх, иргэд, олон нийтэд чиглэсэн төрөл бүрийн аргахэмжээзохионбайгуулахадоршижбайна.

ЯпонулсынШизуокамужийнгазартариалангийнасуудалэрхэлсэнгазрындарга, судалгаашинжилгээниймэргэжилтэннарСэлэнгэаймагтайлчиллаа.

ӨнгөрсөнжилЯпонысубагоймонгийнтүүхийэдболохгурвалжинбудаагЗүүнбүрэн сумандамжилттайтариалсанюм.

Энэудаахамтынажиллагаагааулаамөргөжүүлэхзорилгоорнарийнногоотариалах, түүний төрлийгнэмэгдүүлэхчиглэлээрхэлэлцээхийлээ.

Орхонтуул сумын төрийн сангийн эрсдэлд суурилан түүврийн арга хэрэглэн 07 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд тус сумын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Шалгалтын явцад илэрсэналдаа дутагдлыг арилгуулахаар 23 чиглэлийн зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг гарган ирүүлэхийг анхаарууллаа.

2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр орсон их хэмжээний борооны улмаас буусан үерийн гамшгийн үйл ажиллагаанд аймгийн Онцгой комисстой хамтран ажиллаж гамшигт өртсөн газруудын зургийг гаргах, далан үерийн шуудууг сэргээн засах ажлын трассын

хэмжилт зураглал хийх, Сүхбаатар сумын хэмжээнд бохирдсон талбайн эрүүл халваргүйжүүлэлтийн зураглалыг хийж ажилласан.

Аймгийн хэмжээнд ойн санг гэрээгээр эзэмшигч иргэд, нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол зэрэг сумдын ойн нөхөрлөлүүдийн ахлагч, гишүүд зэрэг 200 гаруй иргэнд сургалтыг явууллаа. Сургалтанд оролцогчдод ойн дагалт баялаг ашиглах, ойжуулалт, мод үржүүлгийн газар байгуулах, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр мэдээлэл хүргэлээ.

Мэргэжлийн хяналтын чиглэлээр:

Үндэсний их баяр наадмаар “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS-6264:2018 стандартыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг 10 дугаар сарын 01-ний дотор гаргаж ирүүлэхийг үүрэг болгож ажиллалаа. Мөн Ардын хувьсгалын 97 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн баяр наадмаар хурдан морь унасан унаач хүүхдүүдийн аюулгүй байдалд Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдыг 3 өдрийн турш ажиллуулсны үр дүнд 9 насны морьдыг унасан 200 гаруй унаач хүүхдүүдээс хамгаалалтын хувцасгүй хүүхэд уралдаагүй бөгөөд нийт 7 хүүхэд мориноос ойчсоноос өөрөөр гэмтэж бэртсэн тохиолдол гараагүй болно.

Хүүхэд хамгаалал, хоол хүнсний аюулгүй байдал, хэрэглэгч сонголтоо зөв хийх талаар олон нийтийн цахим сүлжээнд соён гэгээрүүлэх талаар 4 постер мэдээллийг байршуулж, “Хоол хүнсний гаралтай халдвар, хордлогын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх”, “Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” тухай зөвлөмжүүдийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохиролын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол Улсын хуулийн танилцуулга семинар Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж, үндэсний тохирлын тэмдэг эрхлэх эрхтэй аж ахуйн нэгж байгууллага, итгэмжлэгдсэн лабораторийн ажилтан, албан хаагчдыг хамруулсан сургалтанд хэлтсийн бүх ажилтнууд хамрагдсан.

Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Баруунбүрэн, Сайхан, Түшиг, Шаамар сумын 19 аж ахуй нэгж, иргэний 10 хүнсний дэлгүүр, 2 минимаркет, 5 зоогийн газар, 1 зочид буудал, 1 гэр буудал, 2 амралтын газрын үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 21 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатайгаар олголоо.

Сайхан сумын “Хөтөл дээжис” цехийн үйлдвэрлэсэн бялуун бүтээгдэхүүнийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлж, сорилт шинжилгээний үр дүнг үндэслэн бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээг хэрэглэх эрхийг 2 жилийн хугацаагаар сунгалаа.

“Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн Сүхбаатар салбартай хамтран Түшиг, Цагааннуур, Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн сумын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 154 ширхэг цахилгааны тоолуурыг шалгаж баталгаажуулав.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн байгууллагуудын санхүүжилтийг тавьж олгосон байна. Үүнд:

Орон нутгийн байгууллагууд- 1241.9 сая төгрөг

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд- 1536.6 сая төгрөг

Санхүүгийн дэмжлэг-401.5 сая төгрөг

Нягтланбодохбүртгэлийнтухайхууль шинэчлэгдэн батлагдаж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Сангийнсайдын2016 оны 41 дүгээртушаалаарбатлагдсан “Ажахуйннэгж, байгууллагынангилал,

шалгуурзүүлэлтийг тогтоох журам"-аар нийт аж ахуйн нэгжүүдийг үндсэн хөрөнгө, борлуулалтын орлогын байдлаар нь том болон жижиг дунд аж ахуйн нэгж болгон ангилсан. Үүний дагуу аймгийн хэмжээнд бүртгэлтэй 2004 аж ахуйн нэгж байгууллагаас 141 аж ахуйн нэгжийг том аж ахуйн нэгжийн ангилалд хамруулан жилд хоёр удаа, 1863 аж ахуйн нэгжийг жижиг, дунд аж ахуйн нэгжийн ангилалд хамруулан жилд нэг удаа санхүүгийн тайлан тушаахаар болсон бөгөөд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 141 аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлан гаргаж нэгтгүүлэхээс 131 аж ахуй нэгж байгууллага эхний хагас жилийн санхүүгийн тайлан илгээж, 10 аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлан ирүүлээгүй ба тайлан ирүүлэлт 92,9 хувьтай нэгтгэгдлээ.

Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэртөрөл		2018 V - сар	2018 VI - сар	<u>2018- VI</u> <u>2018- V</u> /төгрөгөөр/
1. ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
	Талх /ороннутгийн, ш/	1 100	1 100	100.0
	Нарийнбоов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэнчихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хониныхмах /кг/	6 500	6 500	100.0
	Үхрийнмах /кг/	8 000	7 500	93.8
	Адууныхмах /кг/	6 000	5 800	96.7
	Ямааныхмах /кг/	5 500	5 500	100.0
	Дотормах, цувдай /цусгүй/	3 500	3 500	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	800	100.0
	Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
	Тараг /задгай, л/	1 200	1 000	83.3
	Хорхойааруул /задгай, чихэртэй, кг/	12 000	13 000	108.3
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурайсүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлынтос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөнтос /кг/	1 500	2 000	133.3
	Шартос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 200	100.0
	Лууван /кг/	1 200	1 200	100.0
	Манжин /кг/	1 500	1 500	100.0
	Байцаа /кг/	1 500	1 500	100.0
	Сонгино /кг/	1 500	1 500	100.0
	Өргөстхэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алагсалат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 530	1 645	107.5
	Бензин А - 92	1 735	1 795	103.5
	Дизелийн түлш	2 020	2 105	104.2

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

2018 оны эхний хагас жилийн байдлаар 238 холбогдогчтой 579.3 сая төгрөгийн хохирол бүхий 368 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 16хэргээр буюу 4.5 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 41.7 хувьтай байна. Мөн оны эхний хагас жилд 9708 зөрчлийг илрүүлэн шалгаж Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2997 зөрчлөөр буюу 23.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, түвшин тогтоох үнэлгээ хийх”, “Төрийн албаны болон мэргэжлийн ёс зүйн тухай ойлголт”, Хог хаягдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль зэрэг хууль, тогтоомжийн сургалт, сурталчилгааны ажлыг Зүүнбүрэн, Алтанбулаг, Ерөө, Сүхбаатар сумдад зохион байгуулж давхардсан тоогоор 601 иргэнийг хамруулан мэдээлэл, гарын авлагаар ханган ажиллалаа.

Архивын чиглэлээр:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөний дагуу Орхонтуул сумын ЗДТГ, Баруунбүрэн сумын ЗДТГ-ын хөмрөгийн нийт 3132 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж заалт 2541, хүний нэр 13955, байгууллагын нэр 493, газар зүйн нэр 809-г шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлагийн чиглэлээр:

Ардын хувьсгалын 97 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулж уг арга хэмжээнд 200 гаруй уран бүтээлч, ардын авъяастан, инженер техникийн ажилтнуудыг хамрууллаа. Хурдан морины салбар комисс болон уяач нарт уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэл, зөвлөмжийг танилцуулан мэдээлэл өгч, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллалаа. Хурдан морины уралдаанд 334 унаач хүүхэд оролцсон бөгөөд эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлтэй хүүхдийг био скайнер ба хурууны хээгээр карт уншигчийг ашиглан цахим бүртгэлд орууллаа.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2018 оны эхний 06 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 832 байсан бол 130 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 112 ажлын байранд 90 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 61 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 811 болсон байна.

Сумдын нийгмийн бодлого, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх зорилго бүхий ажилд зуучлах үйлчилгээний сургалтыг Европын холбоо /SECiM/-ны төсөлтэй хамтран 2018 оны 07 дугаар сарын 16-наас 19-ний өдрүүдэд зохион байгуулж 30 албан хаагчийг сургалтанд хамруулан ажиллалаа.

Нийгмийн халамжийн сангаас оны эхний 07 сарын байдлаар 36774 иргэнд 8.440.251.0 мянган тө

грөгийг олгоод байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2474 иргэнд 2.477.100.8 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1579 иргэнд 681.221.8 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1540 иргэнд 544.509.0 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 2903 иргэнд 297.919.8 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 392 иргэнд 85,629,1 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 1839 эхэд 241.804.6 төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 41 иргэнд 50.336.1 мянган төгрөг

- “Алдарт Эх” одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8447 иргэнд 1,128.120.0 мянган төгрөг
- Насны хишиг 4391ахмад настанд 680,400,0 төгрөг
- Цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 5710 иргэнд 1.687.374.2 мянган төгрөг
- Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн хүрээнд 198 иргэнд 75,200.0 мянган төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 230 иргэнд 14,352,0 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 7030 иргэд 476.283.6 мянган төгрөг

3.Эрүүл мэндийн талаар:

Аймгийн Засаг даргын 2018 оны А/253 дугаар захирамжаар -Эх, хүүхэд нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр”-ийг 2018-2023 онд хэрэгжүүлэх 5 зорилт бүхий 30 томоохон үйл ажиллагааг тусгасан арга хэмжээний төлөвлөгөөг батлууллаа.

2018 оны 2 дугаар улиралд Мандал суманд гарсан 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдолд магадлан хэлэлцэх хурлыг 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт зохион байгуулан 30 гаруй өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн их эмч, сумын нэгдсэн эмнэлгийн холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Жавхлант, Шаамар, Сайхан сум, Номгон, Дулаанхаан, Түнхэл тосгонд Герман улсын “Хил хязгааргүй шүдний эмч нар”-ын холбоотой хамтран хүүхэд, ард иргэдийн дундах амны хөндийн эрүүл ахуй, шүдний эмгэгийг оношлох, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үзлэгээр Герман Улсын 25 их эмч, Монгол Улсын 12 туслах эмч болон орчуулагч нар ажиллаж байна.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Залуу гэр бүлийг дэмжих, Монгол зан заншлаа эрхэмлэн дээдлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гэрлэж буй хосуудад “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт мэдээллийг хийж, гэр бүлийн тангараг өргүүлэн, гэрлэлтийн баталгаа гардуулах ажлыг “Хүндэтгэлийн танхим”-д зохион байгууллаа.

Залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах зорилгоор зорилтот бүлгийн 34 гэр бүлд “Гэр бүлийн аз жаргал” сэдвээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний шинэ нэр төрлүүдийг бий болгох суурь үзүүлэлтийг тодорхойлох “Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг 6 сарын хугацаатай 17 сум, 6 тосгонд хэрэгжүүлж байна.Хөтөлбөрийн хүрээнд Үндэсний судалгааны хүрээлэнгээс гаргасан 1500 асуулгын хуудас бүхий номыг нэгтгэлээ.

5. Биеийн тамир, спортын чиглэлээр:

Ардынхувьсгалын 97 жил, Сэлэнгэаймагбайгуулагдсаны 87 жилийнойнбаярнаадмынспортынаргахэмжээндшагай няслах, шагай шүүрэх, шатар, сагсан бөмбөг гэсэн спортын төрлүүдээр насанд хүрэгчид, хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулж дээрх уралдаан тэмцээнүүдэд нийт 70 гаруй наадамчид оролцлоо.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 122 мян.га талбайд уринш бэлтгэхээс өнөөдрийн байдлаар 1 дүгээр шатны боловсруулалтыг бүрэн хийж, 2 дугаар шатны уринш боловсруулалт 60 гаруй хувьтай явагдаж байна.

2018 онд нийт 724676 эх мал төллөхөөс 07 дугаар сарын 25-ны байдлаар нийт 562548 мал төллөж үүнээс ингэ 61, гүү 15272, үнээ 49885, эм хонь 292984, эм ямаа 204346 төллөөд байна. Төлийн хорогдол 4526 үүнээс унага 99, тугал 536, хурга 1892, ишиг 1999 хорогдсон бөгөөд мал төлөлт 78 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол нийт 8126 толгой бөгөөд тэмээ 4, адуу 561, үхэр 1999, хонь 3122 ямаа 2648 үүнээс хээлтэгч мал нийт 2098 үүнээс гүү

92, үнээ 558, эм хонь 812, эм ямаа 336 хорогдсон бол өвчнөөр 358 толгой мал буюу адуу 31, үхэр 100, хонь 107, ямаа 120 хорогдсон дүн мэдээтэй байна.

Үлийн цагаан огтоно устгаж байгаа Баруунбүрэн, Орхонтуул, Сайхан, Сант, Орхон, Баянгол, Мандал сумдаар явж хяналт тавьж ажиллалаа. Уг ажлыг газар цөмлөгч, уураар утагч 2 багажаар хийж байгаа бөгөөд уламжлалт арга болох ус цутган устгаж байна. Сумдууд устгал хийх 2-3 баг гарган сумын газрын даамал байгаль хамгаалагч, багийн даргаараа ахлуулан ард иргэдтэйгээ хамтарч ажилласан байна.

Мал эмнэлгийн албанд Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар Мандал, Цагааннуур зэрэг сумдаас ирсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий 51 дуудлаганд шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Мөн нян судлалын шинжилгээнд Цагааннуур 3, Алтанбулаг сумаас 7 дээж ирсэн. Ийлдэс судлалын төлөвлөгөөт шинжилгээний дагуу 11 сумын 17 МЭҮН-ийн бух 253, үнээ 1340 хуц 512, ухна 396, нийт 2501 малын цусанд бруцеллөз өвчний шинжилгээ хийж халдваргүй болохыг тогтоон ажилласан.

Сүхбаатар сумын худалдааны төв, нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй мал аж ахуйн гаралтай мах, махан бүтээгдэхүүн болох адууны 320кг махны 2 дээж, үхрийн 7200кг махны 45 дээж, хонины 2700 кг махны 106 дээж, ямааны 480кг махны 19 дээж, дайвар бүтээгдэхүүний 200 кг 1 дээж, нийт 8200 кг махны 154 дээж, 600 л сүүний 15 дээжинд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгон ажилласан. Мөн “Мерси кор” олон улсын байгууллагын төлөөлөгчид Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн үйл ажиллагаатай танилцсан.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 15 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажуулсан.

Газрын харилцааны талаар аймгийн Засаг даргын 4 удаагийн захирамж гаргасан байна. Үүнээс:

№	Захирамжийн товч утга	Өргөдлийн тоо		Захирамжаар олгосон газрын хэмжээ /м ² /		Бүгд газрын хэмжээ /м ² /
		Иргэн	ААНэгж, байгууллага	Иргэн	ААНэгж, байгууллага	
1	Газар эзэмшүүлэх тухай	4	-	1685	-	1685
2	Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай	1	1	724	549	1273
3	Газар эзэмших эрх шилжүүлэх тухай	10	-	8581	-	8581
Нийт		15	1	10990	549	11539

Аймгийн Засаг даргын шийдвэр гарсан газар эзэмшигч 16 иргэн, аж ахуйн нэгжтэй нэгж талбарын газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хувийн хэрэг үүсгэж улсын бүртгэлд бүртгэсэн. Сүхбаатар сумын 18 иргэний 18 нэгж талбарын газар эзэмших гэрээг дүгнэж ажилласан байна.

2018 оны 07 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн 25 км бохир усны шугамтай Алтанбулаг сумын бохирын шугмыг холбох ажлыг гүйцэтгэж байгаа “Комфорт импекс” ХХК, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн төлөөллүүд бүхий бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг шугмын налуууд үзлэг хийж шугмын трассд геодезийн хэмжилт хийлгэн зургийн байгууллагад хүргүүлээ.

2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр “Карголанд” ХХК-ийн гүйцэтгэж байгаа 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгад үзлэг хийж ажлын гүйцэтгэлийн 35 хувийг баталгаажууллаа.

Сүхбаатар сумын хэмжээнд үерийн улмаас эвдэрсэн газруудад сэргээн засварлах, үерийн далан байгуулах ажлууд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хүн хүчний оролцоотойгоор хийгдэж байна.



Долоо. Байгаль орчин

Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэж байгаа “Их тайга” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. Тус аж ахуйн нэгж нь Ерөө сумын нутаг Баянголоос 2 тонн хусны навч түүж бэлтгэн орон нутгийн төсөвт 1 400 000 төгрөгийг байгалийн ургамал ашигласны төлбөрийг шилжүүлсэн.

Ерөө сумын Бугант тосгонд үйл ажиллагаа явуулдаг “Сэлэнгэ Бугант” ХХК, “Сосна” ХХК, “Буян-Од” ХХК, “Бугант нандин” ХХК, “Бугант минж” ХХК зэрэг ойн мэргэжлийн байгууллага, “Их хөвч”, “Хөвч” ойн нөхөрлөлүүдийн мод үржүүлгийн газруудын үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор Түшиг сумын нутаг Хар горхийн чиглэлд байгуулсан халз зурвасыг үргэлжлүүлэн хийх талбай тусгаарлалтын ажлыг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги, Хилийн 0243 дугаар ангитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж санхүүжилт 80 хувийг олгон ажлыг эхлүүлсэн.

Найм.Сум орон нутгийн талаар

Алтанбулаг сум:

Сумын 3 дугаар багийн нутаг Ивцэгийн хэсэгт зусаж байгаа малчдад зориулан Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, сумын ЗДТГ-ын 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, хууль, эрх зүйн актуудын тухай мэдээлэл, танилцуулга хийж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч тэдний санал сэтгэгдлийг сонсож ажиллалаа.

УИХ-ын гишүүн Н.Оюундарийн дэмжлэгээр сумын төвд хүүхэд хамгаалах байрыг тохижуулан үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болгосон бөгөөд 2 иргэнийг байнгын ажлын байраар хангасан.

“Нэг иргэн-Нэг ном” хандивын аяныг сумын хэмжээнд өрнүүлж, иргэдээс 275000 төгрөгийн өртөг бүхий 120 ширхэг номоор Соёлын төвийн номын сангийн фондыг баяжуулан иргэдэд үйлчилж байна.

Зүүнбүрэн сум:

Монгол Улсын Засгийн газраас томилогдсон ажлын хэсгийн боловсруулсан “Ардын засаглал” хөтөлбөрийн төслийг иргэдэд танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцогчдоос гаргасан санал нь уг хөтөлбөрийн утга агуулгатай давхцаж байлаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/34 дүгээр тушаалаар “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг 2018 оны 06 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэл зохион байгуулахаар төсвийн байгууллагуудын “Ёс зүйн хороо”-ны дарга нарт даалган аяны хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллахыг төр, төсвийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болголоо.

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 1/303 тоот албан бичгийн хүрээнд голын усны түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан үер усны аюулаас болгоомжлохыг анхааруулсан сэрэмжлүүлгийг худалдаа, үйлчилгээний газруудын мэдээллийн самбарт байршуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, сумын Засаг даргын Тамгын газар хамтран Монгол Улсын Засгийн газрын “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” 2018 оны 131 дүгээртөгтоол, малчид тариаланчдын зохицлыг хангах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор “Малчидтай уулзах өдөрлөг”-ийг Мангиртын 3 дугаар багийн Цацын нуга хэмээх газар зохион байгуулж, уг арга хэмжээнд ардын авьяастан болон соёлын биет бус өв тээгч нарыг хамрууллаа.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 1 ахмад настанг хамруулж 560.000 төгрөгийн урамшуулал, залуучуудын гарааны бизнесийн дэмжих хөтөлбөрт 1 багийг хамруулж 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус олголоо.

Жавхлант сүм:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаан хуралдаж, өвөлжилтийн бэлтгэл, 2019 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын саналыг эрэмбэлэх, 2018 онд сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн биелэлтийг хэлэлцлээ.

2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор сумын Засаг даргын 2018 оны 10 тоот албан даалгавар, сумын Засаг даргын захирамжийг гарган өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсгийг байгуулан 7 хоног бүр биелэлтийг тооцон ажиллаж байна.

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Соёл урлаг хүний хөгжилд” аян, “Соёл урлаг үндэсний дархлаа” уриан дор Соёлын төвөөс нүүдлийн номын сан, “Нэг өрх нэг ном” аян зэрэг арга хэмжээг зохион байгуулж, соёлын биет бус өв тээгчдийн судалгаа гарган морин хуур, бий биелгээний шавь сургалтыг Бумбат 1-р багийн Хүйтэний гол, Шарын гол, Моностой 2-р багийн Ерөө голын урд 4 хэсэгт иргэдийн дунд зохион байгуулан явуулын соёл урлагийн үйлчилгээг хүргэн ажиллалаа.

Мандал сүм:

Тус суманд үйл ажиллагаа явуулдаг сум дундын Цагдаагийн хэлтсийн 60 жилийн ойн баярын арга хэмжээ 07 дугаар сарын 20-ны өдөр тохиосон бөгөөд ойн хүрээнд хэлтсийн байрыг шинэчилэн засварлах зэрэг бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тамхины тухай хуулийн хэрэгжилтийг хангах, өсвөр насны хүүхдүүдийг хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын 2018 оны 243 дугаар захирамжийн гарган мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн “Тамхи худалдан борлуулахыг хориглох тухай” мэдэгдлийг багийн Засаг дарга нараар дамжуулан сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны ойр орчим 500 метрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хүргүүлээ.

Сумын ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, Хүүхдийн ордон хамтран гэрч хохирогчийг хамгаалах “Түр хамгаалах байр”-тай болох зорилгоор аймгийн Засаг дарга, ГБХЗХГ-т хүсэлт гаргаснаар 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 өрөө байрыг тохижуулан камержуулж, сантехникийн шугамыг шинэчлэн цонх, хаалганд хамгаалалтын төмөр решотка суулган 2 ажилтны орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулахад бэлэн боллоо.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгээр хөдөлмөр эрхлүүлэх хөтөлбөрт 2 өрхийг хүнсний ногоо тариалах чиглэлээр, 2 өрхийг мал аж ахуйн чиглэлээр хамруулж 2 бүлэгт тус бүр 1 сая төгрөгийг олголоо.

Орхон сүм:

Иргэд олон нийтийн санал сэтгэгдлийг нээлттэй хүлээн авч цаг үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх үүднээс Orkhon Sum Zdtg Selenge Facebook хаяг, “Сэлэнгэ аймаг Орхон сүм” цахим хуудсаар ард иргэдийг үер усны аюул осол, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, тэмдэг тэмдэглэгээтэй газар гол усанд орохгүй байх талаарх сэрэмжлүүлгийг байнга явуулж байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/23 дугаар захирамжаар батлагдсан “Хууль эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа”-ны хуваарийн дагуу тайлант хугацаанд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн сурталчилгааны хуудсыг 3 хүнсний дэлгүүр болон зарын самбаруудад байрлуулан сурталчилсан.

Сумын ЗДТГ-аас хууль сурталчлах ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар 45 иргэнд, Газрын тухай хуулиар 9 иргэнд, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар 23 иргэнд хууль эрхзүйн мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж байгаа бэлчээрийн үлийн цагаан огтонотой тэмцэх ажлын хүрээнд 2018 онд тус суманд 5000 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, сумын Засаг дарга нарын хооронд байгуулсан “Үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй аргаар тэмцэх” 05 тоот гэрээний дагуу зохион байгууллаа.

Орхонтүүл сүм:

Энэ сард аймгийн Засаг даргын эрх шилжүүлсэн сумын Эрүүл мэндийн төвийн морг гражийн дээвэр, хаалга, цонх засварын ажил болон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Баянцогт 2-р багийн Орон сууц хорооллын явган хүний зам тавих ажлын тендер шалгаруулалтыг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг ЗДТГ-н даргын тушаалаар томилон зохион байгууллаа. Эрүүл мэндийн төвийн морг,гражийн дээвэр, хаалга, цонх засварын ажлын гүйцэтгэгчээр “Онъ тэнгэрийн бичиг” ХХК шалгарч гэрээ байгуулаад байна. Баянцогт 2-р багийн Орон сууц хорооллын явган хүний зам тавих 27,969,900 төгрөгийн төсөвтэй ажилд нэг ч компани тендер ирүүлээгүйгээс амжилтгүй болж хуулийн 3 хүртэлж компанид үнийн санал ирүүлэх урилга хүргүүлээд байна.

Түшиг сүм:

2018 оны 07-р сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулсан сумын баяр наадамд оролцох хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах үүднээс сумын “Хамтарсан баг”-ийг байгуулан унаач хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл болон даатгалыг хийлгэн уралдаанд оролцуулаа.

Булган аймгийн Сэлэнгэ сум, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын хилийн цэсийн орчимд гарсан ойн түймрийг 2018 оны 07 сарын 04, 05-ны өдрүүдэд ажиллаж бүрэн унтраасан. Түймэрт өртсөн талбайн хэмжээ 2 га бөгөөд түймэр гарах болсон шалтгаан нь байгалийн гэнэтийн үзэгдэл болох аянганаас болсон гэсэн дүгнэлтийг гаргасан.

Хүдэр сүм:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан төсвийн орон нутгийн давсан орлогоос өрхийг үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд сумын 18-40 хүртэлх насны 40 залуу малчинд 9 сая төгрөгийн өртөг бүхий 40 ширхэг сүүний машин гардуулж өгөв.

Аймгийн ХХААГ-тай хамтран сумдын Хөдөө аж ахуйн тасгийн агрономичдын сургалтыг зохион байгуулан талбайн түүх хөтлөх зааварчилгаа өгч 2 өдөр “Арвин бэлчир” ХХК, “Монгол сафори” ХХК, “Ургац Хүдэр” ХХК-ийн тариалангийн талбайд ургалт, ургалтын явц, өвчин хортонтой тэмцэх талаар төрөлжсөн сургалт явууллаа.

Хог хаягдал үүсгэсний хураамж авах зорилгоор сумын ИТХ-ын тогтоол, сумын Засаг даргын “Хяналтын цэг ажиллуулах тухай” 2018 оны А/113 дугаар захирамжийн хүрээнд 07

дугаар сарын 06-наас15-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт тавьж хуваарийн дагуу Унаган толгой дахь постыг ажиллуулсан.

Шаамар сум:

“Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяны удирдамж, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, сумын төр төсвийн байгууллагын ажилтан албан хаагчдад Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2016 оны 05 тоот албан даалгавар, сумын Засаг даргын А/12 дугаар захирамжуудыг танилцуулан ажлын байрны стрессийг хэрхэн даван туулах чиглэлээр сургалт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Сумын Засаг даргын 2018 оны А/85 дугаар захирамжийн хүрээнд сум, тосгоны баяр наадмын өдрүүдэд хүнсний худалдаа үйлчилгээ эрхэлж буй 25 хуушуурын гэр, хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч 10 иргэн, тоглоомын үйлчилгээ үзүүлж буй 15 иргэдийн үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Мөн Сүхбаатар угтах хаалган дээр хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхэлж байгаа иргэдэд эрүүл ахуйн шаардлагыг мөрдөж ажиллах, зориулалтын хувцас хэрэгсэл өмсөж ажиллахыг мэдэгдлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын ерөнхийн газар болон “Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллагатай хамтран үндэсний хэмжээнд зохион байгуулж буй Гэр бүлийн туршилтын хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсгийн захирамж, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, Дэлгэрхааны 1 дүгээр баг, Охиндийн 2 дугаар баг, Дулаанхааны 3 дугаар багаас нийт 12 өрхийг сонгон судалгаанд хамруулсан бөгөөд 84 өрхөөр гэр бүлийн туршилтын хөтөлбөрийн санал асуулгын хуудсыг бөглүүлэн аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлээ.

БОЛОВСРУУЛСАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ДҮҮРЭНБАЯР

ХЯНАСАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА